

БИЕ ХҮНИЙ ЧИГ ХАНДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Л.Мөнхчулуун¹ Б.Болортуяа² Д.Хишигжаргал¹

¹АШУУИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль
munkhchuluun@mnumns.edu.mn

Хүлээн авсан огноо: 2021.10.21

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор О.Отгонтоогоо

Үндэслэл

Сэтгэл судлалын ухаанд хүн, бие хүн, хувь хүн гэсэн гурван ухагдахуун буюу нэр томъёо хэрлэгддэг. Энэ гурван ухагдахуун угтаа хүний тухай өгүүлэх боловч харилцан ялгаатай. Хүн хувь хүн болж төрөөд бие хүн (Person) болж төлөвшдөг. Бие хүн бүр бие бялдар, сэтгэл зүй, зан төлөвийн хувьд ялгаатай олон шинжийг агуулдаг субъект юм.

Бие хүний төлөвшил бага насанд сууриа тавьж насан турш хөгжиж байдаг. Иймд бага насны суурь хүмүүжил хувь хүний төрөлхийн сэтгэл зүйн онцлог боловсрол, ажлын дадлага туршлага хамт олны уур амьсгал найз нөхдийн хүрээлэл гээд тухайн бие хүнд байнгын ойрын нөлөөлдөг орчин нэн чухал юм. Бие хүний идэвхт чанараа танин мэдэж, тэдгээрийг хувьсган өөрчлөхөд чиглэгдсэн олон янзын олон талт үйл ажиллагаагаар бие хүний идэвхтэй чанар илэрхийлэгдэж байдаг байна. Бие хүн нь нийгэм, түүхийн бүтээгдэхүүн. Бие хүнийг төлөвшүүлэн хөгжүүлэх процесс нь сургалт хүмүүжлийн иж бүрэн ажлын үр дүн юм. Дээд боловсролын чанарын үнэлгээ нь зөвхөн мэдлэг олгодог, шалгадаг аргаас мэдлэгээ хэрэглэх, дүн шинжилгээ хийж нэгтгэн дүгнэх, үр дүнг тооцох чадвар, бүтээлч сэтгэхүй төлөвшил хандлагыг нь үнэлдэг системд шилжих бодлогыг БСШУСЯ-ны “ДЭЭД БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ 2016-2020” баримт бичигт тусгасан байна.

Сэтгэл судлаач Карол Двек амжилтыг IQ биш хандлага тодорхойлдог гэдгийг баталсан байна. Оюутны хөгжил төлөвшлийн хандлага нь сургалтын орчин, нийгмийн үйл ажиллагаа, гэр бүлийн орчиноос шалтгаалдаг байна.

Оюутны сурах хөдөлмөрт болон мэргэжилдээ хандах хандлага, идэвх санаачлага нь тэдний суралцах хугацааны туршид олон хүчин зүйлээс хамаардаг байна. Анагаахын мэргэжилтний цогц чадамжид тусгасан шаардлагын дагуу зөв хандлагатай мэдлэг чадвар бүхий мэргэжилтэнг бэлтгэхэд шинээр элсэн суралцаж буй оюутнуудын ямар чиг хандлага давамгайлж байгааг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг хийв.

Түлхүүр үг: Хандлага, Бассын асуумж, нийгмийн харилцаа, орчин

Зорилго

- Дархан-Уул аймаг дахь АУС-ийн 1-р дамжааны оюутнуудын бие хүний чиг хандлагыг тодорхойлох

Судалгааны арга зүй

Судалгаанд Дархан-Уул аймаг дахь АУС-ийн 1-р дамжааны 100 оюутнаас Б.Бассын бие хүний чиг хандлагыг тодорхойлох 27 асуулт бүхий асуумжийг google forms ашиглан авлаа.

Судалгааны үр дүн

Асуумжийг үнэлэхдээ хамгийн их үнэлэмж өгч буй хэсэгт 2 оноо, нийцэхгүй байгаа хэсэгт 0 оноо, бөглөхгүй орхиход 1 оноо өгсөн болно. Нийт 27 асуултын хариултуудыг тус бүрд нь нэмж тооцлоо. Энэ аргачлалыг ашиглан дараах хандлагыг тодорхойлов. Өөртөө хандсан /Я/- Түгшүүр, цухалдуу зан, өрсөлдөх сонирхол, эрх мэдэл, байр суурь олж авахыг эрмэлзэх, урамшуулал шагналд дуртай.

- Харилцаанд хандсан /О/- ямар ч нөхцөлд хүмүүстэй харилцаа тогтоох, хамтран ажиллах сонирхолтой ч ихэнхи тохолдолд хүмүүст чин сэтгэлээсээ тусламж үзүүлэх эсвэл ганцаараа тодорхой даалгавар биелүүлэх чадвар сул, бүлгээс хамаралтай.
- Ажил хэрэгч чиглэсэн /Д/- Энэ нь өөрийн үзэл санааг ажлын сонирхолд нийцүүлсэн, ажлыг илүү сайн гүйцэтгэх, ажил хэргийн асуудлыг шийдвэрлэх явдал

Хүснэгт 1. Үсгэн үнэлгээ

№	я	о	д	№	я	о	д
1	б	а	в	15	в	а	б
2	в	б	а	16	б	в	а
3	а	б	в	17	б	в	а
4	б	а	в	18	в	б	а
5	а	в	б	19	а	б	в
6	б	а	в	20	а	б	в
7	б	а	в	21	а	в	б
8	а	б	б	22	б	в	а
9	б	а	в	23	б	в	а
10	б	в	а	24	а	в	б
11	а	в	б	25	б	а	а

12	в	а	б	26	а	б	в
13	б	а	в	27	в	а	б
14	б	а	в				

Хүснэгт 2. Тоон үнэлгээ

01.А /Я/ 2 оноо	15.Б/О/ 1оноо
03.А/Я/ 2 оноо	16.Б/О/ 1оноо
04. А/Я/ 2оноо	18. А/Я/ 2 оноо
05. Б/О/ 1 оноо	19. А/Я/ 2оноо
06. Б/О/ 1оноо	20.А/Я/ 2оноо
07. Б/О/ 1 оноо	21. Б/О/ 1оноо
08. А/Я/ 2 оноо	22. Б/О/ 1 оноо
09.Б/О/ 1оноо	23. А/Я/ 2 оноо
09.Б/О/ 1оноо	24. Б/О/ 1 оноо
10. А/Я/ 2 оноо	25. А/Я/ 2 оноо
12. Б/О/ 1оноо	26. А/Я/ 2оноо
13. Б/О/ 1оноо	

Судалгаанаас үзэхэд өөрт хандсан хандлагатай оюутнууд нь бүлгээс хамааралтай, багаар ажиллах сонирхол бүхий хандлагатай оюутнуудаас илүү байна.

Дүгнэлт

- Нэгдүгээр дамжаанд элсэн суралцагчдын өнөөдрийн чиг хандлага нь өрсөлдөх сонирхолтой, өөрийн байр суурийг эрхэмлэсэн шинжтэй байна.
- Ихэнхи тохолдолд хүмүүст чин сэтгэлээсээ тусламж үзүүлэх эсвэл ганцаараа тодорхой даалгавар биелүүлэх болон багаар ажиллах чадвар сул байгаа нь ажиглагдаж байна.
- Иймд зөв төлөвшил, эерэг хандлагатай, хамт олонч, нөхөрсөг, үнэнч шударга, итгэлтэй байдал, сэтгэлээсээ туслах, хүндэтгэх хайрлах зэрэг хандлага бүхий оюутнуудыг бэлтгэх нь чухал байна.

A STUDY ON DETERMINING ATTITUDES OF INDIVIDUALS OF INDIVIDUALS

Abstract

A person is a human being that develops into individual. An individual connotes individualism and properties that are unique to person. Individual differences are found in all physical abilities, knowledge, habits, personality and character traits. Personal development is founded humans at an early age and develops throughout their lives. Therefore, personal development is influenced by the background of childhood, the innate psychological characteristics of the individual, education, work experience, community atmosphere, and close circle of friends. The individuals are product of society and history. The process of personal development is the result of a comprehensive educational work.

For the transition to a system in which the quality assessment of higher education is based solely on the use of knowledge, the ability to analyze and summarize knowledge, the ability to evaluate results, and the development of creative thinking are outlined in a policy document by "HIGHER EDUCATION POLICY AND PLANNING 2016-2020" of the Ministry of Education, Culture and Science.

This study was conducted to determine in the enrollment of new students in training professionals with the right attitudes and knowledge in accordance with the requirements of the comprehensive competence of medical professionals.

The following survey was conducted to determine the individual attitude of the first year students of the Medical School in Darkhan-Uul aimag. The current tendency of the first year students is to be competitive and to value their position.

-In most cases, there is a lack of ability to provide sincere assistance to people, to perform certain tasks alone and to work in a team.

Therefore, it is important to prepare students with the right and positive attitude, teamwork ability, friendliness, honesty, trustworthiness, and sincere.

Ном зүй

1. <http://soyolerdem.edu.mn/online/wp-content/uploads/2017/03/hunii-hogjil-h-es-zui.pdf>
2. [Creating room for personalization](#)
3. <https://core.ac.uk/download/84137013.pdf>
4. Боловсрол судлал 2017 он "EQ сайжруулахын тулд хэрэгжүүлэх 4 алхам" 6
5. <https://www.facebook.com/GreeksInMelbourneJoinOneJoinAll/photos/quote-from-aristotle-educating-the-mind-without-educating-the-heart-is-no-educat/821832471248758>
6. https://web.sonoma.edu/users/s/swijtink/teaching/philosophy_101/paper1/goleman.htm –
7. Д.Эрдэнэчулуун "Удирдахуйн сэтгэл судлал" 2013 он УБ
8. Д.Болормаа "Байгууллагын зохион байгуулалтын зан төлөв" 2002 он УБ
9. Дейл Карнеги "Нөхдөө өөртөө татаж хүмүүст нөлөөлөх ёсон" 1991 он УБ
10. О.Мягмар, О.Мөнхжаргал "Харилцааны сэтгэл зүй" 2008 он УБ